

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 7338 дугаарт бүртгэв.

ГОВЬСҮМБЭР АЙМАГ СҮМБЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2024 оны 12 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 05

Сүмбэр сум

МАЛЫН ТОО ТОЛГОЙД НОГДОХ АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, 52 дугаар зүйлийн 52.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Тус сумын малын тоо толгойд ногдох албан татварын хэмжээг адуунд 0, үхэрт 0, ямаанд 0, хонинд 0, тэмээнд 0 төгрөг байхаар тус тус тогтоосугай.

2.Тогтоолын хэрэгжилтийн тайланг бүтэн жилээр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга /Э.Даваадорж/-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг тооцож ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль, орчин хөдөөгийн хөгжлийн хорооны дарга /Б.Мөнхбаяр/-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

Т.ТҮМЭНБАЯР

БУЛГАН АЙМГИЙН ОРХОН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ VI ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 7 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 06/03

Орхон сум

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Хог хаягдлын тухай хуулийн 9.1.4, 9.2.2 дахь заалт, Татварын Ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.23 дахь заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1.Сумын төвийн өрхийн болон хог хаягдлын хураамжийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Уг тогтоолыг “Захиргааны хэм хэмжээ”-ний актын эмхэтгэл”-д нийтэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдүүлсүгэй.

3.Тогтоолыг хуулийн хугацаанд нь холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын нарийн бичгийн дарга /Д.Туул/-д даалгасугай.

ДАРГА

Г.ДАШНЯМ

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын ээлжит хуралдааны 2025 оны
06/03 дугаар тогтоолын хавсралт*

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

№	Үзүүлэлт		Хэмжих нэгж	Хураамж (төгрөгөөр)
1	Иргэн (Төв суурин, хөдөөгийн баг)		Сард (төгрөг)	250
2	Төр, төсвийн байгууллага		Сард (төгрөг)	10000
3	Үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэд /эмийн сан, зоогийн газар, гуанз, цайны газар, аймаг хот хооронд хүн болон бусад тээвэр эрхлэгч, үсчин гоо сайхан, халуун ус/ гэх мэт.		Сард (төгрөг)	15000
4	Хүнсний дэлгүүр	Тусгай зөвшөөрөлтэй	Сард (төгрөг)	15000
		Бусад дэлгүүр		10000
5	Хувиараа хөдөлмөр эрхлэгчид /оёдол, гутал засвар гэх мэт/		Сард (төгрөг)	2000
6	Жуулчны бааз, зочид буудал, амралт сувилал		Сард (төгрөг)	25000
7	Дэд бүтэц /банк, шатахуун түгээх станц гэх мэт/		Сард (төгрөг)	25000
8	Дугуй засвар, авто засвар, угаалгын газар		Сард (төгрөг)	10000
9	Явуулын худалдаа, үйлчилгээ /1 удаа/		Тухай бүр	25000
10	Уурын зуухны үйл ажиллагаа эрхлэгч		Тухай бүр	25000
11	Баяр наадам нэгдсэн арга хэмжээний үеэр худалдаа үйлчилгээ явуулж буй иргэн, аж ахуйн байгууллага		Нэг өдөр	30000
12	Фермер, махны үйлдвэр, бусад томоохон үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж		Сард (төгрөг)	25000
13	Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх		Тухай бүр	40000
14	Бусад хог хаягдал (барилга, өтөг бууц, мал нядалгаа) гэх мэт.		Тухай бүр	60000
15	Уул уурхай	"А" лицензтэй	Сард (төгрөг)	100000
		"Х" лицензтэй		100000
16	Тэжээвэр гахай		Сард (төгрөг) /нэг гахайнаас/	1000

УВС АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 8 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 42

Улаангом

ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дахь заалтыг үндэслэн “МӨНХИЙН УНДРАА УВС” ХХК- аас ирүүлсэн хүсэлтийг хэлэлцээд Увс аймгийн зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.“МӨНХИЙН УНДРАА УВС” ХХК –ийн Давст сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс мөрдөж ажиллахыг “ МӨНХИЙН УНДРАА УВС” ХХК -ийн захирал /Ц.ОТГОНБЯМБА /-д даалгасугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Увс аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн “Тариф батлах тухай” 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 11 дүгээр тогтоолыг тариф хэрэгжиж эхлэх өдрөөс хүчингүйд тооцсугай.

4.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн гишүүн/ Т.Цэцэгмаа, Б.Болор /нарт даалгасугай.

ДАРГА

Б.ЭЛДЭВ-ОЧИР

ГИШҮҮН

Т.ЦЭЦЭГМАА
Б.БОЛОР

*Увс аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн
2025 оны 42 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт*

ДАВСТ СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ТАРИФ

№	Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ/-гүй
1	Үйлдвэр, аж ахуйн нэгжийн халаалт	1М ³	1500
2	Төсөвт байгууллагын халаалт	1М ³	2762
3	Айл өрхийн халаалт	1М ²	1000

ХАРИЛЦАА ХОЛБООНЫЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 6 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 139

Улаанбаатар
хот

“ДАРАА ҮЕИЙН ХӨДӨЛГӨӨНТ ХОЛБООНЫ СИСТЕМД АШИГЛАХ РАДИО ДАВТАМЖИЙН ЗУРВАСЫН ХУВААРИЛАЛТ, ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА”-ЫН ХОЛБОГДОХ ХЭСГИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 127 дугаар зүйлийн 127.5, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, Монгол Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүх хуралдааны 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 001/ХТ2024/0117 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Тус хорооны 2023 оны 106 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ын 4.5 дэх хэсгийг хүчингүй болгосугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР
Б.БАТЗОРИГ
Ч.ЗОЛБАЯР
А.ЛУВСАН-ОЧИР
А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 он 7 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 183

Улаанбаатар
хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.5 дахь заалт, 79 дүгээр зүйлийн 79.1, 79.5 дахь хэсэг, 81 дүгээр зүйлийн 81.4 дэх хэсгийг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 57 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”-д доор дурдсан агуулгатай дараах заалтыг нэмсүгэй:

1/ 3.10.5 дахь заалт:

“3.10.5.Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх;”

2/ 3.10.6 дахь заалт:

“3.10.6.Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх.”

3/ 3.11.5 дахь заалт:

“3.11.5.Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх.”

4/ 5.4.6 дахь заалт:

“5.4.6.нэр дэвшигч хоёр ба түүнээс дээш шүүхийн шүүгчийн сул орон тооны сонгон шалгаруулалтад нэг зэрэг нэрээ дэвшүүлсэн бол энэ журмын 5.1.1.1-д заасан шалгалтыг тухайн сонгон шалгаруулалтын явцад нэг удаа өгнө.”

2.Энэ тогтоолыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ГИШҮҮН

Д.ЗҮМБЭРЭЛЛХАМ

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН ТУШААЛ

2025 оны 8 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар А/60

Улаанбаатар
хот

ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, “Гадаадын албан ёсны баримт бичгийг баталгаажуулах шаардлагыг халах конвенц”-д Монгол Улс нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн 3 дугаар зүйл, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Журам шинэчлэн батлах тухай” Гадаад харилцааны сайдын 2022 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн А/86 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан «Баримт бичиг баталгаажуулж, “Апостиль” гэрчилгээ олгох журам»-ын 2 дугаар хэсэгт дор дурдсан агуулга бүхий заалтыг нэмсүгэй:

1.1./“2.17. Үйлчлүүлэгч нь баримт бичгийг баталгаажуулах хүсэлтээ цахимаар гаргасан тохиолдолд “Апостиль” гэрчилгээ цахим хэлбэрээр олгогдоно. Цахим хэлбэрээр олгогдох “Апостиль” гэрчилгээг Консулын газрын холбогдох ажилтан цахим гарын үсгээр баталгаажуулна.”.

2. Мөн журмын 2 дугаар хэсгийн 2.2.1-ийн төгсгөлд “/Цахимаар олгох “Апостиль” гэрчилгээний хувьд Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем болох E-Mongolia портал дээр тус үйлчилгээг авахад бөглөх хэсгийг ойлгоно” гэж нэмсүгэй.

3. Журмын дараах заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

3.1./2.7 “Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем болох E-Mongolia портал, түргэн үйлчилгээний цэгээс гарган авсан баримт бичгийн лавлагаа, тодорхойлолтын эх хувийг нотариатчаар гэрчлүүлсэн байхыг шаардахгүй бөгөөд тус баримт бичгийг хэрэглэх улсын хэлээр авснаас бусад тохиолдолд баталгаат орчуулгыг нотариатчаар гэрчлүүлж хавсаргасан байна. Үйлчлүүлэгч нь дээрх лавлагаа, тодорхойлолтыг QR кодоор уншуулж үнэн, зөвийг урьдчилан шалгаж нягталсан байх үүрэгтэй.”;

3.2./2.13. “Апостиль” гэрчилгээний гарчиг нь франц хэл дээр үйлдэгдсэн байх бөгөөд бусад өгөгдлүүдийг нь англи, монгол хэлээр тус тус бичнэ. “Апостиль” гэрчилгээнд Консулын газрын захирал, эсхүл

дэд захирал, эсхүл Консулын газрын баримт бичиг баталгаажуулалт хариуцсан албан хаагч гарын үсэг зурж, “Апостиль” гэрчилгээг баталгаажуулах баталгааны тэмдгийг дарна.;

3.3./3.3. “Цахимаар олгосон “Апостиль” эрчилгээг Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем болох E-Mongolia порталаас тухайн «Апостиль» гэрчилгээний дугаараар, эсхүл QR кодоор олгосон эсэхийг шалгах боломжтой.”

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Гадаад харилцааны сайдын 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/86 дугаар тушаалын 6 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.БАТЦЭЦЭГ

БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

сарын 15-ны өдөр

Дугаар А/192

XOT

ЖАГСААЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Боловсролын сайдын 2025 оны “Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай” А/404 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Боловсролын сайдын 2025 оны “Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай” А/404 дүгээр тушаал шинэчлэн батлагдсан холбогдуулан “Боловсролын ерөнхий газрын даргын 2023 оны “Жагсаалт батлах тухай” А/273 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийн жагсаалт”-д дор дурдсан агуулга бүхий дараах жагсаалтуудыг нэмсүгэй.

Сургалтын хэрэглэгдэхүүн									
14	Будгийн нийлүүр	Цагаан өнгөтэй, хүүхэд хэрэглэхэд тохиромжтой байх	-	Урт 5см-7см	Урт 7см-9см	Урт 5см-7см	Урт 7см-9см	Урт 5см-7см	Урт нь 7см-9см
15	Бийр угаах усны сав	Тагтай, бийр угаах зориулалттай байх	-	1ш	1ш	1ш	1ш	1ш	1ш
16	Жижиг самбар	A4 хэмжээтэй, цагаан өнгөтэй, зурах, дүрслэх зориулалттай	-	-	1ш	-	1ш	-	1ш

Эрүүл ахуйн хэрэгсэл

10	Усны сав (хүүхдэд зориулсан)	Хүүхдэд зориулсан усны сав нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: Хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүнсний зориулалтын (BPA-free (Bisphenol A) агуулаагүй), тагтай, авч явахад авсаархан, цэвэрлэхэд хялбар байна. Савны хэмжээ нь тухайн насны хүүхдийн гарын атгалт, өдөр тутмын шингэний хэрэгцээнд тохирсон, 200-350 мл багтаамжтай байх Жич: Хүүхдэд ус уух зөв дадал бий болгох, шингэний дутагдлаас сэргийлэх зорилгоор гэр, цэцэрлэгийн орчинд хүүхдэд зориулалтын усны сав хэрэглүүлж болно. Хүүхэд хэрэглэж буй усны савны эрүүл ахуй, ариутгал, цэвэрлэгээг эцэг эх, асран хамгаалагч хариуцна.
----	------------------------------------	---

11	Хормогч, ханцуйвч	Сургалт, үйл ажиллагаанд шаардлагатай үед хэрэглэнэ. (усан будаг, гуашаар ажиллах, энгийн хөдөлмөрийн хийх, туршилт, танин мэдэхүйн үйлд оролцох гэх мэт)
12	Нарны малгай, солих хувцас	Цэцэрлэгийн орчинд ургамал, амьтан, байгалийн үзэгдлийг ажиглах, турших, элс, ус, шороо, ургамалтай харьцаж, танин мэдэх, хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн сургалт, үйл ажиллагаанд шаардлагатай тохиолдолд өмсөж болно.

2.Мөн жагсаалтын сургалтын хэрэглэгдэхүүний 6 болон 13 дугаар хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

Сургалтын хэрэглэгдэхүүн									
6	Зургийн дэвтэр	Үдээстэй дэвтэр: А4 хэмжээтэй, ус даадаг, зузаан цаастай байх	2ш	2ш	2ш	2ш	3ш	1ш	1ш
			12 хуудас	20 хуудас	24 хуудас	20 хуудас	24 хуудас	20 хуудас	24 хуудас
		Үдээсгүй дэвтэр: Хуудсыг салгаж зурах зориулалттай байх	1ш	2ш	2ш	2ш	2ш	1ш	1ш
			20 хуудас	20 хуудас	24 хуудас	20 хуудас	24 хуудас	20 хуудас	24 хуудас
13	Хайч	Үзүүр нь мохоо, тагтай, хүүхдийн гарт тохирсон байна. Хайчлах урт нь 5см -9см байх	-	1ш	1ш	1ш	1ш	1ш	1ш
			-	Урт нь 5см-7см	Урт нь 7см-9см	Урт нь 5см-7см	Урт нь 7см-9см	Урт нь 5см-7см	Урт нь 7см-9см

3.Мөн жагсаалтын сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалтын цагийн зохицуулалт дахь “Ердийн цэцэрлэг” гэснийг “Ердийн цаг (8-10 цаг), уртасгасан цаг (11-12 цаг)-ийн бүлэг” гэж, “24 цагийн цэцэрлэг/бүлэг” гэснийг “Уртасгасан цагийн бүлэг” (24 цагийн) гэж, “Хувилбарт сургалт” гэснийг “Хувилбарт сургалтын бүлэг” гэж тус тус өөрчилсүгэй.

4.Нэмэлт, өөрчлөлт оруулсан захиргааны хэм хэмжээний актыг бүртгүүлэх ажлыг холбогдох хуульд заасан шаардлагын дагуу гүйцэтгэхийг Хууль, эрх зүйн хэлтэс (Г.Олонбаяр)-т даалгасугай.

5.Энэхүү тушаалаар оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлэхээр өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэгүүдэд хүргүүлэх, эцэг эх, асран хамгаалагч нарт мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээний хөгжлийн

газар (Б.Лхагвабаяр), аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

6.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Х.Чинтогтох)-т даалгасугай.

ДАРГА

Т.НЯМ-ОЧИР